



АГУУЛГА

1. Нийгмийн даатгалын байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн
2. Нийгмийн даатгалын талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажлын хүрээнд
 - Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тэтгэвэр, тэтгэмжийн чиглэлээр
 - Нэг цэг, цахим үйлчилгээний ажлын чиглэлээр
3. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, төсөв, төсвийн гүйцэтгэл
 - Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар
 - Нийгмийн даатгалын сангийн зарлагын талаар
 - Банкнуудаар хийгдсэн сангийн орлого, зарлагын гүйлгээний талаар
 - Нийгмийн даатгалын сангийн төвлөрүүлэлт, санхүүжилт, үйл ажилаагааны чиглэлээр
 - Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, аудитын байгууллагын дүгнэлтийн талаар
 - Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын талаар
4. “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг, барагдуулах” жилийн хүрүүнд хийсэн ажил
 - Өр барагдуулах ажлын чиглэлээр
 - Даатгуулагчдыг дэмжих ажлын чиглэлээр
5. Төрийн үйлчилгээ, цахим үйлчилгээний чиглэлээр
 - Нийгмийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг өргөжүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх
6. Хууль тогтоомжийн хэрэгжилт хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа
7. Мэдээллийн технологи, сургалт, сурталчилгааны чиглэлээр
8. Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах чиглэлээр
 -
 - Зохион байгуулалтын чиглэлээр
 - Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр
9. Бусад ажлын хүрээнд



ЗОРИЛТ

Тус газар нь нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Алсын хараа-2050”, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хуулийн хэрэгжилтийн хүрээнд дээд газраас ирүүлсэн тогтоол шийдвэр, өгсөн үүрэг даалгавар, зөвлөмж, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, иргэд, даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах нөхцөлийг бүрдүүлэн, үйлчлүүлэгч, хэрэглэгчдийн хэрэгцээг мэргэжлийн түвшинд бүрэн гүйцэд, шуурхай, хүнд сурталгүй, тэгш хүртээмжтэй, бүх талын дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Энэхүү зорилтын хүрээнд хуульд заасан нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагч, ажил олгогчид үзүүлэхдээ нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь тогтоож, олгох, дотоодын хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн үр дүнг дээшлүүлэн ажиллаж байна.


Нийгмийн даатгалын ерөнхий газраас 2025 оныг нийгмийн даатгалын салбарын хэмжээнд **“Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах”** жил болгосон зарласан бөгөөд тус зорилтын хүрээнд иргэд, даатгуулагч, ажил олгогчийг дэмжих, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, ач холбогдол, эрх зүйн ойлголтыг, сурталчлах, хамралтыг нэмэгдүүлэх зорилтыг тавин ажиллаа.

НЭГ. БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/238 дугаар тушаалаар тус газар нь батлагдсан орон тоо (53), төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах, сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх арга хэмжээний хүрээнд 2025 оны байдлаар албан тушаалын 6 сул орон /удирдах 4, гүйцэтгэх 2/ тоог зохих хууль тогтоомжийн дагуу нөхөж, Төрийн албаны салбар зөвлөлөөс ирүүлсэн тогтоолыг үндэслэж албан хаагчийг томилон, Нийгмийн даатгалын ерөнхий газарт орон тооны мэдээг сар бүр, тогтоосон хугацаанд маягтын дагуу хүргүүлэн ажиллаж байна.



Байгууллагын бүтэц, зохион байгуулалт (НДЕГ-ын А/238 тушаал)



Тус газрын ажилтан, албан хаагчид өдөр тутмын үйл ажиллагаандаа албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэн, иргэд, даатгуулагч болон ажил олгогчдод нийгмийн даатгалын үйлчилгээг чирэгдэлгүй, тасралтгүй, хурдан шуурхай хүргэн ажиллаж байна. Тус газрын ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйг чанд мөрдүүлэх, төрийн үйлчилгээний ил тод, шударга, шуурхай байдлыг хангах, цаг ашиглалтыг сайжруулах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор 2025 оны “Сургалтын хөтөлбөр”, бусад байгууллагын сургалтад тухай бүр хамруулсан.

Мөн газрын ажилтан, албан хаагчид “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г газрын төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэгтэй уялдуулан боловсруулж, хэлтсийн дарга нар баталсан бөгөөд биелэлт, тайланг хагас, бүтэн жилээр албан хаагч тус бүрээр танилцуулж, гүйцэтгэл, үр дүнг тооцон ажиллаа.



ХОЁР.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАЛААР ТӨРИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБООТОЙ АЖИЛ

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх тэтгэвэр, тэтгэмжийн чиглэлээр


Газрын тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс нь иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын багц хууль болоод бусад хууль тогтоомж, дээд газраас ирүүлсэн тогтоол, шийдвэр, чиглэл, зөвлөмжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, холбогдох тайлан мэдээг цаг хугацаанд нь тайлагнан ажиллаж байна. 2025 оны жилийн эцсийн байдлаар Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн ажилтан, албан хаагчид сар бүр тэтгэврийн тогтоолтын тооцоог хийж, хуулийн хугацаанд олгон, олголтыг долоо хоногт 4-5 удаа хийж тэтгэвэр авагчдад хүндрэл, чирэгдэл учруулахгүй хурдан шуурхай үйлчилж байна.

Тэтгэвэр олголтын тайланг сар бүр хороо, арилжааны банкны салбараар нэгтгэн гаргаж, тэтгэврийн даатгалын сангийн зарлагын харилцахтай тохируулан ерөнхий болон зарлагын нягтлан бодогч нар сар бүр баталгаажуулан олгож ажиллаж байна.

(2025 оны тэтгэвэр олголтыг сараар ангилан харуулав.)



САР	ХҮНИЙ ТОО	ОЛГОСОН ТЭТГЭВЭР /сая төгрөгөөр/
1-Р САР	24658	22.962.300.00
2-Р САР	24773	22.986.900.00
3-Р САР	24993	22.998.900.00
4-Р САР	24996	23.066.600.00
5-Р САР	24982	23.096.000.00
6-Р САР	24989	23.389.300.00
7-Р САР	25052	23.348.980.00
8-Р САР	25119	23.423.002.00
9-Р САР	25204	25.519.269.00
10-Р САР	25231	23.582.163.00
11-Р САР	25320	23.606.216.00
12-Р САР	25397	23,581,768,00
Өссөн дүнгээр	300714	281.561.398.00
Дунджаар сард олгох тэтгэвэр	25100	23.083.333.00

СҮҮЛИЙН 4 ЖИЛИЙН ТЭТГЭВЭР АВАГЧДЫН ТООНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Газрын тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн ажилтан, албан хаагчид 2024 оны жилийн эцсийн тэтгэвэр олголтын тайланг Сикос системээр гаргах ажлыг зохион байгуулж, 2025 оны 01 дүгээр сараас 2025 оны 04 дүгээр сарыг дуусталх хугацаанд илүү цагаар ажиллан, давхардсан тоогоор 54 мянган тэтгэвэр авагчийн хуваарь, нэхэмжлэл, олголтыг нэг бүрчлэн тулган шалгаж, сарын дундуур жагсаалтаар



олголтуудыг үүсгэн Сикос системд оруулан, шалгалт хийж, тэтгэврийн олголтын тайланг амжилттай гаргаж хүлээлгэн өгсөн.

Шинэ систем нэвтрүүлж байгаатай холбоотой системээс илгээж болохгүй байгаа олголтуудыг Мэдээлэл технологийн төвд хүргүүлэн 100% системээс олголт хийдэг болоход анхаарал тавин ажиллаж байна. Улсын байцаагчийн актын суутгал болон нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд хуваан олгогддог тэжээгчээ алдсаны тэтгэврийн программ хөгжүүлэлт бүрэн хийгдээгүй тул жагсаалтаар эксел файл үүсгэн олгож байна.

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, Банкны төлбөр барагдуулах газраас ирүүлсэн тогтоолын дагуу нийт 45 тэтгэвэр авагчаас 50 хувиар суутган тооцож нийт 198,5 сая төгрөгийг тус тус тооцон шилжүүлсэн.

Тус газар нь 2025 оны жилийн эцсийн байдлаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд зааснаар нийт 19378 даатгуулагчдад 26.1 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон байна.

(Тэтгэмжийг төрлөөр ангилан харуулав)

ТЭТГЭМЖИЙН ТӨРӨЛ	ТОО	МӨНГӨН ДҮН
Тэтгэмжийн даатгалын сан	17483	14.328.647.00
Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж	578	1.156.000.00
Жирэмсний болон амаржсаны тэтгэмж	1889	8.359.158.00
Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж	15016	4.813.489.00
ҮОМШӨ-ний даатгалын сан	370	1.688.924.00
ҮОМШӨ ХЧА тэтгэвэр	120	1.118.378.00
ҮОМШӨ ТА тэтгэвэр	18	133.764.00
ҮОМШӨ Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж	232	436.782.00
Ажилгүйдлийн даатгалын сан	2150	10.381.228.00
Ажилгүйдлийн тэтгэмж	2150	10.381.228.00
Нийт	20003	26.118.799.00

➤ **Нэг цэг, цахим үйлчилгээний ажлын чиглэлээр**

Тус газрын Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэст харьяалагдаж байгаа Нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн тасаг нь шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдэд зөвлөгөө өгөх, материал хүлээн авах, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийг олгох зэрэг нийгмийн даатгалын бүхий л чиглэлээр даатгуулагчдад мэдээллээр хангах, тэтгэврийн хувийн хэрэг хариуцан баяжуулалт хийж ажиллаж байна.



Мөн түүнчлэн ажил олгогч, иргэд даатгуулагчдад төрийн үйлчилгээг нэг дороос авах боломжтой “Хурдан” цэгийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлэн ажиллуулж эхэлсэн боловч Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн А/238 тушаалаар бүтэц, орон тооны өөрчлөлт батлагдаж “Цахим үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн”-ий албан тушаал нь цомхогдсон тул III улирлаас эхлэн уг үйлчилгээ хэвийн үзүүлэх боломжгүй болсон. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар “Хурдан” системээс нийт 817 иргэнд 1015 хуудас бүхий лавлагаа тодорхойлолт гарган ажилласан ба дор дурдсан графикт лавлагааны төрөл, сараар ангилан харуулав.


(График)

№	Лавлагааны төрөл	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар	7 сар	8 сар	9 сар	Нийт
1	Гэрлэсний бүртгэлийн лавлагаа	2	2	2	2	4	5	3	2	6	28
2	диплом хуулбар						1				1
3	Иргэний оршин суугаа хаягийн лавлагаа	2		4	2	6	21	11	9	16	71
4	Иргэний үнэмлэхний лавлагаа	36	7	16	37	23	11	9	6	8	153
5	жолоочийн лавлагаа					1					1
6	Зээлийн мэдээллийн лавлагаа				1						1
7	мэргэшсэн жолоочийн үнэмлэхний лавлагаа					1					1
8	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа	48	11	12	47	45	65	41	38	26	333
9	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа /Нас барсан хүүхдийх/	1									1
10	Оршин суугаа газрын хаягийн лавлагаа	3	2		3	4	2	3	3	2	22
11	Тогтоолтын хуудас		9	1	7	3	4	2	2	8	36
12	Тогтоолтын хуудас англи	1		1	1						3
13	төрийн албан хаагчийн тодорхойлолт		1								1
14	Төрсний бүртгэлийн лавлагаа	7	3	4	4	1					19

15	Төрсний гэрчилгээний лавлагаа хүүхдийх (1)	18		8	18	6	18	12	10	14	104
16	Тэтгэвэр тогтоолтын лавлагаа	1			2	1					4
17	Тэтгэвэр авдаг тухай тодорхойлолт /Англи/	2									2
18	хөдөлмөрийн чадвар алдалтын актын лавлагаа	4		4	6	2	5	3	4	8	36
	Нийт	125	35	52	130	97	132	84	74	88	817

Бид иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээг илүү хүртээмжтэй, түргэн шуурхай хүргэх, цахимаар тэтгэмжийн хүсэлтийг илгээх боломжийг бүрдүүлэх зорилгоор тусгай киоск төхөөрөмжүүдийг нэг давхарт байршууллаа.

Энэхүү киоск машинаар иргэд өөрийн нийгмийн даатгалын мэдээлэл, шимтгэл төлөлт, тэтгэврийн тооцоо, лавлагаа авах зэрэг үйлчилгээг цахим хэлбэрээр хурдан шуурхай, төвөггүй авах боломжтой болсон.



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭХ, ТӨСӨВ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

➤ Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлтийн талаар

Тус газрын хамралт, орлогын хэлтэс нь салбарын Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жил болгон зарласантай холбогдуулан албан журмын болон сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг ерөнхий хууль болон шинэчлэгдсэн багц хууль, түүнтэй холбоотой эрх зүйн актууд, Гэр бүл хөдөлмөр нийгмийн



хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар, газрын даргын өгсөн чиг үүргийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Тайлант хугацаанд сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд хамруулах, нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах сургалтын төлөвлөгөөг гарган, газрын даргаар батлуулан шат дараалсан арга хэмжээг авч байгаа бөгөөд үүний үр дүнд сайн дурын даатгалд шинээр нийт 1,630 даатгуулагч үүнээс шинээр гэрээ байгуулсан 1,270 даатгуулагч, 0-3 насны хүүхдээ асарч буй эх 240, малчин 5, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг /эх/ 175 даатгуулагчийг тус тус хамруулсан байна.

Аж ахуй нэгж бүртгэж хамруулах ажлын хүрээнд төлөвлөгөө гарган долоо хоног бүрийн ажлын 2 өдрүүдэд байцаагч нар нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгэлгүй аж ахуйн нэгжийг эрж хайх замаар тус дүүргийн оффис барилгаар хуваарийн дагуу явж нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах, мэдээлэл өгөх замаар бүртгэлд хамруулан ажиллаж байна.

Мөн дүүргийн Татварын хэлтсээс шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн жагсаалтыг албан бичгээр авч, нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлээгүй аж ахуйн нэгжүүдтэй холбогдон бүртгүүлэх арга хэмжээг тус тус авч ажилласнаар шинээр 673 ажил олгогч бүртгүүлж үүнээс 590 ажил олгогч 2,258 албан журмын даатгуулагчийг хамруулж 8,277.1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг санд төлж төвлөрүүлэн ажилласан.

Нийгмийн даатгалын сангийн орлогын сар, улирал бүрийн төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж, нийт 736,454.1 сая төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, төлөвлөснөөс 736,454.5 сая төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 100 хувиар биелүүллээ.

(Орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар харуулав.)

2025 оны орлогын төлөвлөгөөний биелэлт			
Сар	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	44,817,473.90	46,899,272.00	109.49
2	46,152,612.20	50,986,571.00	112.79
3	57,647,120.90	53,892,422.70	95.10
I улирал	148,617,207.00	151,778,265.70	104.93
4	57,869,526.50	57,784,655.80	98.86
5	62,050,619.00	67,807,871.40	97.37
6	66,392,137.40	66,392,137.40	90.63
II улирал	186,312,282.90	191,984,664.60	95.43
7	56,318,638.60	57,225,195.4	101.61



8	62,625,778.40	56,623,966.5	90.42
9	66,321,023.9	56,329,403.7	84.93
III улирал	185,265,440.9	170,178,565.6	91.86
10	66,551,821.6	59,777,039.5	89.82
11	69,941,673.1	56,180,881.0	80.33
12	79,765,655.7	116,567,855.7	146.14
IV улирал	216,259,150.4	232,525,776.2	107.52
НИЙТ	736,454,081.2	736,454,540.2	100%

(Нийгмийн даатгалын сангийн орлогыг төрлөөр нь ангилан харуулав.)



СҮХБААТАР ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗАР

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО



➤ Нийгмийн даатгалын сангийн зарлагын талаар

Тус газар нь нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах, батлагдсан




төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан.

(Нийгмийн даатгалын сангийн зарлагыг төрлөөр нь ангилан харуулав.)



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА



➤ **Банкнудаар хийгдсэн сангийн орлого, зарлагын гүйлгээний талаар**

Монгол Улсын Сангийн сайд, Хөдөлмөр, нийгэм хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246/A/245 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Маягт журам батлах тухай”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/65 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг тус тус мөрдлөг болгон баримтлан ажиллаж байна.

Төрийн сан, Төрийн банк, Худалдаа хөгжлийн банк, Капитрон банк, Голомт банк, Хаан банкаар орж ирсэн сайн дурын болон ажил олгогчдын нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээлэл болон тэтгэвэр тэтгэмжийн зардлыг банкны хуулгатай тулган банкны хуулганы тайлан, мөнгөн харилцах дансны үлдэгдлийн өдөр бүр тулган мэдээллийг оруулж мэдээллийн санг бүрдүүлсэн.

Мөн нэр, регистр тодорхойгүй гүйлгээг банкны данс эзэмшигчийн жагсаалт болон мэдээллийн сангаас олох, банканд жагсаалт хүргүүлэн мэдээлэл солилцох ажлын хүрээнд ажил олгогч ба даатгуулагчийн нэр дээр залруулан бүртгэж мэдээллийн санг үнэн зөв болгосон. Мөн арилжааны банкнудаас харилцахын чөлөөт үлдэгдэлд тооцох хүүг “Хамтран ажиллах гэрээ”-нд заасны дагуу Капитрон, Төр, Голомт, Худалдаа хөгжлийн банкуудаар 199,5 сая төгрөгийн хүүгийн

тооцооллыг баталгаажуулж Нийгмийн даатгалын ерөнхий газарт төвлөрүүлэн ажилласан.

Төвлөрсөн харилцах дансанд орлогын гүйлгээг банк бүрээр мэдээллийн санд оруулсан байдал

№	Банк	Гүйлгээний тоо	Орлогын дүн /сая төгрөгөөр/	Зарлагын дүн /сая төгрөгөөр/
1	Төрийн сан	4454	129,764,126,120.6	126,150,861,145.5
2	Төрийн банк	8094	18,912,984,092.44	18,912,276,306.99
3	Худалдаа хөгжлийн банк	18279	214,977,818,891.99	214,961,466,435.36
4	Капитрон	9619	19,023,499,052.36	19,023,499,095.87
5	Хаан	58944	255,648,824,713.10	263,138,076,740.32
6	Голомт	13098	67,821,718,651.35	67,842,391,951.48
Нийт дүн		112488	706,148,971,521.84	710,028,571,675.32

Нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн мэдээ, тайлан гаргах ажлын хүрээнд арилжааны банкнуудаас ирсэн төвлөрсөн сангийн хуулгыг үнэн зөв бүртгэж, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 3-ны өдөр цаг хугацаанд нь үнэн зөв гарган цахимаар хүргэн ажиллав.

Илүү төлсөн шимтгэлийн буцаалтыг даатгуулагч тус бүрээр хянаж, 39 хүнд 359,5 сая төгрөгийн буцаан олголтыг олгож, холбогдох данснуудад хуваарилалт хийсэн.



Нийгмийн даатгалын сангийн бүх төрлийн данснуудаас цахимаар гүйлгээ хийхдээ төвлөрсөн орлогын дансыг буруу сонгосноос залруулгын гүйлгээ нэлээдгүй гарсантай холбоотойгоор 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс банк хоорондын гүйлгээг IBAN дансаар хийх болсонтой холбогдуулан дансны тохиргоог шинэчлэн тус газрын цахим хуудсан дээр харилцах дансны дугаарын жагсаалтыг шинэчлэн тавьж, ажил олгогч байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт заавар зөвлөмж мэдээлэл өгч ажилласан.

➤ **Нийгмийн даатгалын сангийн төвлөрүүлэлт, санхүүжилтийн талаар**



Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 05/777 тоот албан бичгийн хэрэгжилтийг хангаж, Нийгмийн даатгалын төвлөрсөн орлого дансанд 2025 оны байдлаар нийт 850,000,00 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 198,784.0 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авч ажилласан.

(Санхүүжилт, төвлөрүүлэлтийг сан тус бүрээр харуулав).

Д/д	Даатгалын сан	Төвлөрүүлсэн дүн	Санхүүжилт авсан дүн
1	Тэтгэврийн даатгалын сан		171,825,336.00
2	Тэтгэмжийн даатгалын сан		14,892,300.00
3	ҮОМШӨ даатгалын сан		1,634,000.00
4	Ажилгүйдлийн даатгалын сан		10,433,360.00
	Нийт	850,000,000.00	198,784,996.00

➤ **Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны санхүүжилт, зардал**



Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай, Монгол Улсын төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн хэмнэлтийн горим баримтлан ажилласан.

Нийгмийн даатгалын үйл ажиллагааны жилийн 2,950.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас төсвийн хуваарьт 8 удаа өөрчлөлт орон 2025 оны 12 дугаар сарын сүүлийн баталсан төсвийн хуваариар 2,695.0 сая төгрөг буюу 255,3 сая төгрөг хасагдан батлагдсан. Дээрх төсвийн батлагдсан хуваарийн дагуу зардлыг төсвийн ангиллын дагуу зарцуулан хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцон 2025 оны санхүүгийн тайлангаар тооцоолол судалгаагаа тухай бүр хүргүүлэн ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй батлагдсан орон тоогоор ажилласан.

2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчдын цалинг 6 хувиар нэмэгдсэнтэй холбоотой ажилчдын цалингийн тооцооллыг тухай бүрт нь хийж Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж ажилласан.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай, Монгол Улсын төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн хэмнэлтийн горим баримтлан өр, авлага үүсгэхгүй байх тал дээр анхааран ажиллаж байна.

Үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Цалин хөлс, нэмэгдэл урамшил	2,163,240.2	2,163,240.2



2	НДШ	280,843.3	280,843.3
3	Тогтмол зардал	47,240.1	47,240.1
4	Бараа материал болон үйлчилгээний бусад зардал	30,176.0	30,176.0
5	Харуул хамгаалалт, зөвлөл хороодын зардал	76,555.2	76,555.2
6	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, бусад зардлууд	77,229.2	77,229.2
7	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	14,630.9	14,630.9
8	Бусад	5,165.6	5,165.6
Нийт		2,695,080.5	2,695,080.5

Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, аудитын байгууллагын дүгнэлтийн биелэлт, хэрэгжилт

Нийгмийн даатгалын байгууллага, сангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг “Солид Юнити Аудит” ХХК санхүүгийн аудит хийж, байгууллагын тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт гаргасан болно.

Сангийн тайлангийн аудитыг нийслэлийн салбарын хэмжээнд түүвэр байдлаар хийгдсэн бөгөөд уг аудитын үр дүнд нэг зөвлөмж тавигдсан. Аудитаас өгсөн энэхүү зөвлөмжийг залруулах арга хэмжээг авч, цаашид ижил төстэй зөрчил, дутагдал давтан гаргахгүй байх тал дээр анхааран ажилласан бөгөөд зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх төрийн аудитын газарт хүргүүлсэн болно.

Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн мөрөөр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Бараа материалын Sicos программд бараа материалын дэлгэрэнгүй болон хураангуй тайлан бэлтгэгдэж, Нягтлан бодох бүртгэлийн Green системд программын үлдэгдэл нь зөв татагдан тайлан гарч байгаа боловч бараа материалын дэлгэрэнгүй бүртгэл Excel хэлбэрт дутуу хөрвөж байсан зөрчлийг арилгуулахаар программ хангамж хариуцсан байгууллагад уламжилж, засварлуулан зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн.
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээг батлагдсан төсвийн гүйцэтгэлийн хуваарийн дагуу тооцон, тухай бүр тогтмол сар бүр байршуулж, мэдээллийг ил тод, нээлттэй хүргэж байна.



- Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд бүртгүүлж, цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг 2025 онд худалдан авах боломжоор хангагдсан.

2025 оны санхүүгийн тайлангийн аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК хийж гүйцэтгэн аудитын явцад шаардлагатай мэдээ мэдээллийг тухай бүрт нь хүргүүлэн ажиллаж байна.

-Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт, хамгаалалтын талаар

Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/29 дүгээр тушаалын дагуу өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдийг шинэчлэн 7 гишүүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. “Өмч хамгаалах байнгын зөвлөл” 12 удаа хуралдаж Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын шийдвэр, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудаас баталсан тогтоол шийдвэр, хууль тогтоомж эрх зүйн актуудыг мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажилласан. Байгууллагын өмчийн хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын талаар дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглах боломжтой хөрөнгийн цаашид ашиглах жил, өртгийг шинэчлэн тогтоох, ашиглалтын шаардлага хангахгүй болсон 3 төрлийн 4 ширхэг 12,078,210 төгрөгийн хөрөнгийг ашиглах хугацааг дахин 2 жилээр сунгуулах, 1 ширхэг 1,234,090 төгрөгийн хөрөнгийг актлах, тавилга эд хогшлын 3 төрлийн 16 ширхэг 1,481,184 төгрөгийн эд хогшлыг ашиглах хугацааг 2 жилээр сунгах, 7 төрлийн 39 ширхэг 6,864,197.33 төгрөгийн хөрөнгийг дахин ашиглах боломжгүй тул данснаас хасах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн, ирсэн шийдвэрийн дагуу үндсэн хөрөнгийг үнэ шинэчлэн тогтоож, шинээр бүртгэж хөрөнгийн хөдлөлийг нягтлан бодох бүртгэл, тайланд бүрэн тусгаж хэрэгжилтийг тайлагнасан.
- Тус газрын нэгдүгээр давхрын үйлчилгээний 9.66 м.кв талбайтай өрөөг банк санхүүгийн зориулалтаар Капитрон банканд сарын 193,200 төгрөгөөр түрээсэлж байгаа бөгөөд түрээсийн гэрээг жил бүр Нийгмийн даатгалын ерөнхий газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газартай гурвалсан гэрээг хийж гэрээг жил бүр сунгаж ажиллаж байна. 2024 оны НД-77/24 дугаар түрээсийн гэрээний сунгалтын 2025 оны 01 дүгээр сард хийж гүйцэтгэсэн ба 2025 оны байдлаар түрээсийн төлбөрт 40% 2,318,400 төгрөгийн түрээсийн орлогыг НДЕГ-ын холбогдох дансанд төвлөрүүлсэн.
- Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/12 дугаар тушаалын дагуу эд хөрөнгө тооллого хийх ажлын хэсэг байгуулж 06 дугаар сарын 18-ний өдрөөс 06 сарын 27-ны өдрийн хооронд эд хөрөнгийг эзэмшигч бүрийн хөрөнгийг эд хөрөнгийн карттай тулгаж, тооллого хийх үеийн тэмдэглэлийг хөтөлж, комиссын хурлаар

тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын дүнг баталгаажуулсан. Эд хөрөнгийн тооллогын явцад дутсан хөрөнгө болон зөрчил гараагүй болно.


- Тус газрын гэрчилгээний баталгаажилтыг газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системд бүртгүүлж гэрээний хугацааг 2034 оны 12 дугаар сарын 17-ны өдрийг хүртэл сунгасан.

Тус газрын төрийн өмчийн хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас 2025 оны 3, 4 дүгээр саруудад иж бүрэн хяналт шалгалт хийгдэн, шалгалтын мөрөөр илэрсэн зөрчил, алдаа дутагдлыг арилгах талаар шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөөг газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/21 дүгээр тушаалаар батлуулан, биелэлтийг хангуулж, хянаж ажиллахыг холбогдох ажилтан, албан хаагчдад үүрэг болгож зөрчлийг гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна.

Дээрх шалгалтын мөрөөр хийсэн ажлын тайланг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр ТӨБЗГазарт тайланг хүргүүлэн хамгаалж урьдчилсан байдлаар 100 хувь буюу “бүрэн хангалттай” дүгнүүлэн ажилласан.

Тус газрын конторын барилга 2018 онд ашиглалтад орсноос хойш урсгал засвар хийгдээгүй, гадна фасад болон дотор хана ан цав үүсэн хагаралт үүсэн, өвлийн улиралд дулааны алдагдал ихтэй, өрөө тасалгаанууд хүйтэн, орчин нөхцөл тав тухгүй, байнгын тоос тоосонцор ихтэй, хүйтний улиралд нүүрсний дутуу шаталтын улмаас агаарын бохирдол утаа, тортог ихээр үүсдэг ажлын байрны эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, эрүүл ажлын байрыг бий болгох зайлшгүй шаардлага үүссэний дагуу төсөвт зардлыг суулгах саналаа бүх холбогдох дээд газруудад хүргүүлэн ажилласан.

Дээрх хүсэлтийн дагуу Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын шийдвэрээр тус газрын барилгын гадна фасадны зардлыг шийдвэрлэн баталж СБД ЗДТГ-ын Худалдан авах хэлтсээс тендерийг зарласан бөгөөд тендерт “Нью синдикат” ХХК шалгаран 535,9 сая төгрөгийн барилгын гадна фасадны засварыг 2025 оны 07 дугаар сараас 2025 оны 10 дугаар сарын хооронд хийж гүйцэтгэсэн.





ДӨРӨВ. ДААТГУУЛАГЧДЫГ ДЭМЖИХ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨРИЙГ БАРАГДУУЛАХ” ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Өр барагдуулах ажлын чиглэлээр

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 2025 оны “Даатгуулагчдыг дэмжих, өр авлагыг барагдуулах” жил болгон зарласан бөгөөд энэ ажлын хүрээнд тус газарт бүртгэлтэй аж ахуйн нэгжийн хуримтлагдсан авлагын хэмжээ насжилтыг тодорхойлсон судалгааг гарган, “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын А/199 дүгээр журмын дагуу шат дараалсан арга хэмжээг авч ажиллаж байна.

Хуримтлагдсан авлагын хэмжээ насжилтыг тодорхойлсон судалгааг гарган “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын дагуу шат дараалсан арга хэмжээг авч ажилласны дүнд 2025 оны эхний 4,854 ажил олгогчийн авлага 88,620.2 сая төгрөг байснаас оны эхний авлагыг барагдуулсан байдлаар:

- 2,407 ажил олгогч 27,175.9 сая төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж үүнээс 1026 ажил олгогч 7685,6 сая төгрөгийн өрийг бүрэн төлж өр үүсгээгүй,
- 1381 ажил олгогч 19,490.3 сая төгрөг оны эхний өрөө төлсөн боловч 27,540,8 сая төгрөгийн өр энэ онд нэмж үүссэн байна.
- Оны эхний авлагыг бүрэн барагдуулаагүй 2,447 ажил олгогчийн 72,279.8 сая төгрөгийн авлагаас 445 ажил олгогчийн 41,704.6 сая төгрөгийн авлагаас 8,708,4 хэсэгчлэн барагдуулсан.
- 2025 онд 2,002 ажил олгогч 30,575.1 сая төгрөгийн авлагыг огт барагдуулаагүй тул хүснэгтийн дагуу дараах арга хэмжээг авсан болно.



СҮХБААТАР ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗАР

ДААТГУУЛАГЧДЫГ ДЭМЖИХ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ӨР БАРАГДУУЛАХ ЖИЛИЙН
ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ



2024 оны эцсийн нийт авлагын хэмжээ: 88,6 тэрбум төгрөг

- Үүнээс бүрэн барагдуулсан: 27,175,9 сая төгрөг (2407 ажил олгогч)
- Хэсэгчлэн барагдуулсан: 19,490.3 сая төгрөг (445 ажил олгогч)



Албан шаардлага - 239 ААНБ-ын 5,7 тэрбум төгрөгийн авлагад шаардлага хүргүүлснээр 12 ААНБ-ын 46,3 сая төгрөгийн авлага барагдуулсан байна.



Данс хаасан – 2,494 ААНБ-ын 45.0 тэрбум төгрөгийн авлагатай байгууллагын харилцах данс хааснаар 295 ААНБ-ын 4,1 тэрбум төгрөгийн авлагыг бууруулан ажилласан байна.



Уулзалтаар – 49 ААНБ-ын 3,9 тэрбум төгрөгийн өр авлагын талаар уулзалт хийж холбогдох хариуцлага болон дараагийн авах арга хэмжээг танилцуулсан.



Өр барагдуулах гэрээ – 265 ААНБ-тай 41,6 тэрбум төгрөгийн авлага барагдуулах гэрээ байгуулан 250 ААНБ-ын 3,8 тэрбум төгрөгийг санд төлүүлж гэрээний биелэлтээ ханган ажиллаж байна.



Шүүхэд шилжүүлсэн – 1 ААНБ-ын 1,1 тэрбум төгрөгийн авлагад Нийгмийн даатгалын хуулийн дагуу арга хэмжээ авч алданги тооцон шүүхийн байгууллагад шийдвэрлүүлэхээр материалыг шилжүүлсэн.




Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн – 3 ААНБ-ын 5,2 тэрбум төгрөгийг шилжүүлсэн бөгөөд 1 ААНБ-ын 304,6 сая төгрөгийг барагдуулсан.

Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын Шимтгэл хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Б.Батсүхээр ахлуулсан ажлын хэсэг 2025 оны 03 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд газрын Хамралт, орлогын хэлтсийн хамралт, орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч, өр, авлага хариуцсан мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 100 сая төгрөгөөс дээш нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй аж ахуйн нэгж, байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, гэрээ байгуулан ажилласан. Энэ ажлын үр дүнд тус газрын 7323.9 сая төгрөгийн шимтгэлийн өртэй 27 аж ахуй нэгж байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, өр барагдуулах гэрээ байгуулан хамтарч ажилласан.



Нэрэмжит жилийн ажлын хүрээнд тус газраас нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн 40-50 аж ахуй нэгжийг 7 хоног бүрийн даваа гаригт хурлын танхимд уулзалт зохион байгуулж, нийгмийн даатгалын мэдээ мэдээллийг хуулийн хүрээнд сурталчлан, шимтгэлийн өр авлагыг хуримтлуулснаас даатгуулагчид үүсэх эрсдэл, хуулийн талаарх ойлголтыг өгч, хуулийн хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг төлөхийг анхааруулж, мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаж байна.



Нийгмийн даатгалын ерөнхий газраас ажил олгогчийг дэмжих итгэлцлийн аяныг 2025 оны 09.15-10.15-ны хооронд зохион байгуулж ажил олгогч, даатгуулагчтай уулзалт хийх, өөрийн цахим хуудсанд сурталчлан таниулж дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.



Нийгмийн даатгалын ерөнхий газраас ажил олгогчийг дэмжих итгэлцлийн аяныг 2025 оны 09.15-10.15-ны хооронд зохион байгуулж ажил олгогч, даатгуулагчтай уулзалт хийх, өөрийн цахим хуудсанд сурталчлан таниулж дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

Аяны хүрээнд 18 ажил олгогчийн арилжааны банк дахь харилцах дансны зарлагын гүйлгээг аяны хугацаанаас өмнө хаасан ажил олгогчийн дансыг нийгмийн даатгалын шимтгэлийн 10 хувийг төлүүлж данс нээж 398,7 сая төгрөгийн авлагаас 201,1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлүүлсэн.

Ажил олгогчийн шимтгэлийн хуримтлагдсан өрийн дүнгийн 10 хувиас багагүй хэмжээгээр төлж барагдуулсан тул ажилгүйдлийн 1 даатгуулагчийн 10,9 сая төгрөгийн тэтгэмжийг бодож олгосон.

Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өртэй 67 ажил олгогчийн гүйцэтгэх удирдлагатай уулзалт зохион байгуулж, шимтгэлийн өрийн дүнгээс 10 хувиас багагүй хэмжээгээр төлж ирүүлсэн хүсэлтийн дагуу 6 сар хүртэлх хугацаатай өр төлөх нарийвчилсан хуваарь, тэмдэглэл, гэрээ үйлдэж баталгаажуулсан.

13,3 тэрбум төгрөгийн төлбөр зөрчлөөс 1,1 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлагыг төлүүлсэн.

Хуримтлагдсан шимтгэлийн өртэй 77 ажил олгогчийн 2,3 тэрбум төгрөгийн шимтгэлийн авлагыг төлүүлж ажиллаа.

- **Даатгуулагчдыг дэмжих ажлын чиглэлээр**


Хамралт, орлогын хэлтэс нь нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлээгүй аж ахуйн нэгжийг илрүүлэх, шинээр аж ахуй нэгж бүртгэж хамруулах ажлын төлөвлөгөө гарган тус дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй барилга, оффисоор хуваарь гарган ажлын 2 өдрүүдэд ажилтан, албан хаагч, байцаагчид биечлэн явж газрын цахим хуудсанд нэгдэж нийгмийн даатгалтай холбоотой мэдээ мэдээлэл авах, нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулснаар 98 аж ахуйн нэгж, 552 албан журмын даатгуулагч шинээр хамруулан ажилласан үр дүнтэй байна.



Тус газар нь даатгуулагчийг дэмжих ажлын хүрээнд Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангах, хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг танилцуулах мөн зөвлөгөө мэдээ мэдээллийг өгөх зорилгоор ажил олгогчийн зөвлөгөөнийг 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр зохион байгууллаа. Тус зөвлөгөөнд “Нийгмийн даатгалын шинэчлэл” сэдвээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, төлөвлөгөөний газрын дарга Ц.Ганцэцэг, “Нийгмийн даатгалын шимтгэл, даатгуулагчийн төрөл”-ийг сэдвийн хүрээнд Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн дарга Ч.Эрдэнэчимэг нар танилцуулга, мэдээлэл бэлтгэн хүргэсэн. Зөвлөгөөнд аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, хүний нөөцийн мэргэжилтэн болон нягтлан

бодогчид оролцсон ба дээрх сэдвийн хүрээнд асуусан асуултад хариулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Мөн Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн даатгуулагч, ажилтнуудын нийгмийн баталгааг ханган, нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан нийгмийн хариуцлагыг нь үнэлж “Шилдэг ажил олгогч”-оор 9 аж ахуй нэгжийг өргөмжлөв.




Нэрэмжит жилийн хүрээнд Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх хүрээнд “Бие биеэ дэмжье” аяныг 2025 оны 05-12 дугаар сарыг дуусталх хугацаанд хийхээр зохион байгуулж тус газарт бүртгэлтэй ажил олгогчдын үйл ажиллагааг дэмжин, олон нийтэд сурталчлан таниулж тус ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын Facebook цахим хаягийн дагагчдын тоо 22 000→23500 өссөн үзүүлэлттэй байна.




ТАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

- **Нийгмийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг өргөжүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх**



Тус газарт иргэд, даатгуулагч, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг холбогдох хэлтэс, тасаг, ажилтан, албан тушаалтад хуваарилан шийдвэрлэж буй байдлыг түргэн шуурхай зохион байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд UB Ер программд бүртгэлтэй нийт 335 өргөдөл, гомдол, хүсэлт ирүүлснээс 328 өргөдөл, гомдлыг хугацаанд нь шийдвэрлэж, 7 өргөдлийг хариу өгөхөөр судалж, харин Able программаар НДЕГ-аас ирсэн 270 албан бичиг, бусад дүүрэг, орон нутгаас ирсэн 490 лавлагаа, хүсэлтийг хүлээн авч, илгээж, шийдвэрлэн, 300 албан бичгийг бусад байгууллагад хүргүүлж, илгээж, программд холбогдоогүй төрийн

байгууллагуудад /прокурор, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага, иргэний анхан шатны шүүх, авлигатай тэмцэх газар, цагдаагийн хэлтэс гэх мэт/ цаас болон шуудангаар хүргүүлэн ажилласан. Харин E-doc программд бүртгэлтэй 970 албан бичгээс цаасан болон шуудан, програмаар илгээж хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. Мөн Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах 11-11 төв”-д хандсан 33 гомдол, 3 санал, 2 хүсэлт ирснийг шийдвэрлэн ажилласан байна. Зөрчилтэй, хугацаа хоцроосон албан бичиг, өргөдөл, гомдол байхгүй болно.



Мөн тус газраас иргэн, даатгуулагч, ажил олгогчид нийгмийн даатгалтай холбогдох асуудлаар утсаар мэдээлэл, зөвлөгөө өгөх, утсаар гаргасан иргэдийн өргөдөл, гомдолд тухай бүр шуурхай хариу өгөхөөр ажиллаж байгаа бөгөөд “CallPro” холболтын тусламжтайгаар тухайн ажлыг зохион байгуулж байна.


Иргэд, даатгуулагч, ажил олгогчид утсаар мэдээлэл өгөхдөө тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн, хувийн мэдээллийн нууцлалыг хангаж, шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээг сайжруулах, дуудлага алдалтыг багасгах, дуудлага хүлээн авч буй ажилтан, албан хаагчдын үүргийг хариуцлагажуулах зорилгоор **“Иргэд, даатгуулагч, ажил олгогчид утсаар мэдээлэл, зөвлөгөө өгөх журам”**-ыг боловсруулан газрын даргын 2024 оны А/36 дугаар тушаалаар батлан ажилтан, албан хаагчид дотооддоо мөрдлөг болгон ажиллаж эхэлснээр тухайн газрын “CallPro” үйлчилгээний дуудлагын мэдээгээр сайжирсан үзүүлэлттэй байна.

**Цахим архивын үйл
ажиллагааны
талаар**

Тус газар нь тэтгэврийн хувийн хэргийг цахижуулах зорилгоор баримтуудыг скайнердаж мэдээллийн сан бүрдүүлэх, чип суулгах зэрэг ажлуудыг хийж, тайлант хугацаанд Сүхбаатар дүүргийн нийт 20 хорооны тэтгэвэр авагч 25231 иргэний хувийн хэргийг бүрэн чипжүүлж, 1-7 дугаар хорооны хувийн хэргийн материалыг скайнердаж архивын цахим системд мэдээллийг бүрэн оруулсан. Тэтгэврийн хувийн хэргийг бүрэн чипжүүлж, скайнердаж оруулснаар тус газрын байцаагч, ажилтны ажлын ачаалал буурах, иргэд, даатгуулагч, тэтгэвэр авагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, мөн бусад аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад иргэдийн цахим мэдээллийг солилцох боломжийг бүрдүүлсэн болно.




Тус газар нь 2025 онд Төрийн байгууллагын төгөлдөршилд Азийн жишиг загвар байгууллага болох төслийн хүрээнд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг сайжруулах зорилт тавин ажилласан. Төслийн хүрээнд иргэд, даатгуулагч, ажил олгогчдоос Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2015 оны А/172 дугаар тушаалаар баталсан “Ажил олгогч (даатгуулагч), тэтгэвэр авагч (иргэн)-аас авах сэтгэл ханамжийн судалгааны загвар”, 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн Нийгмийн даатгалын ерөнхий газрын А/184 дүгээр тушаалаар тус тус батлагдсан “Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар сэтгэл ханамжийн судалгаа авах журам”-ын асуултын дагуу сэтгэл ханамжийн судалгааг цаас болон цахимаар авч судалгаанд хуучин маягтаар 403, шинэ маягтаар 413 нийт 816 судалгааг иргэд, даатгуулагч, ажил олгогчдоос авч судалгаанд Азийн бүтээмжийн болон Монголын бүтээмжийн төвийн зөвлөх шинжээчтэй хамтран дүн шинжилгээ хийж, иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжгүй байгаа асуудалд сайжруулалт хийж Төрийн байгууллагын төгөлдөршлийг бий болгосон анхны төрийн байгууллагын нэг болж чадсан.



2.10 Та нийгмийн даатгалын талаарх сурталчилгаа, мэдээллийг хаанаас авдаг вэ?

413 responses



ЗУРГАА. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ШАЛГАЛТ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус газрын хяналт, шалгалтын байцаагчид 2025 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын нийгмийн даатгалын багц хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэсэн ба шалгалтаар илэрсэн зөрчил, төлбөр, зөвлөмжийг тухай бүр өгч ажилласан.

Үүнд: Нийгмийн даатгалын багц хууль болон бусад хуулийн хүрээнд 101 ажил олгогчид Зөрчлийн тухай хуулиар нийт 99.3 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 28 ажил олгогчид хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул татгалзах тогтоол үйлдэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дагуу шийдвэрлэсэн. 186 ажил



олгогчийн 532 даатгуулагчийн 2,088.3 сая төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос 395.5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, 185.7 сая төгрөгийн алдангийг ногдуулж, нийт 581.2 сая төгрөг төлүүлэхээр нийгмийн даатгалын Улсын байцаагчийн акт тогтоож, төлбөр зөрчлийг 100 хувь барагдуулсан.

Тайлант хугацаанд газрын дотоодын хяналт шалгалтаар дараах ажлыг хийж гүйцэтгэсэн.

1. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 01/133 тоот албан бичгийн дагуу 45 сургууль, цэцэрлэг шалгагдахаас 40 байгууллага шалгалтад хамрагдсан.

- Шалгалтаар 175 даатгуулагчтай холбоотой 14 аж ахуйн нэгжид Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн акт тогтоон

- Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44.1.1 дэх заалтыг үндэслэн 699.7 сая төгрөгийн цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос дутуу төлөгдсөн 142.9 сая төгрөгийн шимтгэл 71.5 сая төгрөгийн алданги нийт акт, алданги 214.4 сая төгрөг,

- Зөрчлийн тухай хуулийн дагуу 14 аж ахуй нэгж байгууллагад 29.0 сая төгрөгийн торгууль ногдуулан нийгмийн даатгалын санд 100 хувь барагдуулсан.

- Зөрчилгүй 22 аж ахуйн нэгж байгууллагад Нийгмийн даатгалын хяналт шалгалтын зөвлөмж өгч ажилласан.

2. Тус газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн баталсан “Тэтгэврийн хувийн хэргийн тооллого, олголтыг тулган шалгах” №01 дугаар удирдамжийн дагуу тэтгэврийн нийт идэвхтэй 23354 хувийн хэрэг тоолж, олголтыг тулган шалгаж илүү олгогдсон 24 тэтгэвэр авагчийн нийт 78,2 сая төгрөгийн нийгмийн даатгалын Улсын байцаагчийн акт тавигдсанаас өнөөдрийн байдлаар 78 иргэнтэй холбоотой 349,7 сая төгрөгийн төлбөр зөрчлийн эхний үлдэгдэл дээр өнөөдрийн байдлаар 78,2 сая төгрөгийн актыг шинээр бичиж үүнээс 149,0 сая төгрөгийн төлбөрийг барагдуулсан. Акт тавигдсан тэтгэвэр авагчдийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлж, мөн хуулийн дагуу 50 хувь хүртэлх хэмжээгээр суутгаж төлүүлэн ажиллаж байна.

3. Тус газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн баталсан нийгмийн даатгалын нөхөн тайлантай холбоотойгоор 2024-2025 оны нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн тайлагнасан зөрчилтэй байх магадлалтай 211 аж ахуйн нэгжийн тайланг шалгаж ажилласан. Шалгалтаар илэрсэн зөрчлийн мэдээ, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газар болон хуулийн байгууллагад хүргүүлэж ажилласан.

4. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагад Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж”, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2025 оны 08/2504 тоот албан бичгийн дагуу 107 аж ахуйн нэгж,



байгууллага шалгагдахаас 23 байгууллага шалгалтад хамрагдсанаас 9 аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагааны чиглэл нь эрүүл мэндийн байгууллагатай холбогдолгүй байсан. Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтын дагуу хяналт шалгалтын ажиллагаа явагдаж байгаа болно.

5. Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн нэр бүхий 351 объектоос Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 13-07/02 дугаар “Боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу тус газрын Нийгмийн хамгааллын байцаагчийн эрсдэл бүхий боловсруулах 15 объектод шалгалт хийхээр төлөвлөгдсөний үйл ажиллагаа зогсоосон 7, байгууллага олдоогүй 1 аж ахуйн нэгж байсан. Шалгалтад 7 байгууллага хамрагдаж илэрсэн зөрчлийг холбогдох хууль, хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч, зөвлөмжийг өгч шалгалтын тайлан, мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.

- Тэтгэмжийн даатгалын санд 13 даатгуулагчийн 17,4 сая төгрөгийн төлбөрөөс 17,4 сая төгрөгийг төлүүлсэн.
- 2024 оны ажилгүйдлийн тэтгэмжийн сикос програм дахь мэдээллээс шалгаж зөрүүтэй 2489 даатгуулагчийн авсан ажилгүйдлийн тэтгэмжийн бодолт, олголт, хуваарь, нэхэмжлэх үүссэн, олгосон тэтгэмжийг шалгаж 78 даатгуулагчтай холбоотой 81,3 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлж 27 даатгуулагчийн 13,6 сая төгрөгийг барагдуулж ажилласан.

ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

➤ Мэдээллийн технологийн ажлын хүрээнд

Даатгуулагчийн үндсэн мэдээлэл, төрөл, ажил мэргэжлийн ангилал, кодыг тухай бүр шалган, нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системийн нэвтрэлттэй холбоотой программ хангамжуудын эрхийн тохиргоог байцаагч, нэгж болгоноор үүсгэн шинэ системд ажиллах боломжийг бүрдүүлэн, программ хангамж ашиглалт, аюулгүй байдлыг хангаж байцаагч, нэгж болгонд нууц үг, нэвтрэх нэр үүсгэсэн.

Шинэ системийн сургалтад тухай бүр хамрагдан нийгмийн даатгалын байгууллагын Мэдээлэл технологийн ажилтнуудын цахим мэдээлэл солилцох хуудсаар бүртгэл үүсэхгүй, алдаа заах, систем нэвтрүүлэгчээс зайлшгүй засварлах, хөгжүүлэх шаардлагатай санал болон алдааны заалтыг тухай бүр хүргүүлэн хамтран ажиллаж байна.

➤ Сургалт, сурталчилгааны ажлын чиглэлээр

Тус газар нь нийгмийн даатгалын салбарын хэмжээнд “Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах” жилийн хүрээнд нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд таниулах, сурталчлах, мөн байгууллагын хүний нөөцийг чадавхыг бэхжүүлэх, ажилтан, албан хаагчдыг сургаж хөгжүүлэх зорилгоор ажлын хүрээнд газрын даргын баталсан 2025 онд хийж хэрэгжүүлэх сургалт, сурталчилгааны төлөвлөгөөнд гадагшаа болон дотогшоо чиглэсэн сургалтуудыг тус тус зохион байгуулж дараах онцлох сургалтыг хийсэн байна. Үүнд:

Гадагшаа чиглэсэн сургалтын хүрээнд

1. Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн хэрэгцээнд тулгуурлан татвар, нийгмийн даатгал, компаний тухай хуулийн мэдлэгийг дээшлүүлэх, тогтвортой бизнес, ажлын байрыг бий болгох, бараа бүтээгдэхүүний зах зээлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв”-өөс 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулсан арга хэмжээнд тус газрын албан хаагч мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.



2. Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа их дээд сургуулиудын төгсөх ангийн оюутан суралцагсдын судалгааг гаргаж хүргүүлэн хуваарийн дагуу ШУТИС, АШИУС, Урлах эрдэм дээд сургуулиудад сайн дурын даатгалд хамрагдахын ач холбогдлын талаар 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр мэдээлэл өгч ажилласан.




3. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн санхүү, нягтлан бодогч нарт нийт 50 гаруй албан хаагчдад 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Нийгмийн даатгалын багц хуулийн тухай ойлголт, сургалт мэдээллийг тус газрын Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн дарга Ч.Эрдэнэчимэг мэдээлэл өгч ажилласан байна.



4. Сүхбаатар дүүргийн прокурорын газар, Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газар, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар хамтран зохион байгуулсан “Хорих ангис суллагдсан, ялаас чөлөөлөгдсөн хүний нийгэм, эдийн засаг, соёлын эрхийг хангахад чиглэсэн үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд тус газрын улсын байцаагчид “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн тухай ойлголт” сэдвийн хүрээнд танилцуулга бэлтгэн оролцсон.



5. Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газартай хамтран “Хуульчдын Про Боно өдөрлөг”-т 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр оролцон Нийгмийн даатгалын зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



6. Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран дүүргийн 20 хороодод ажилтан, албан хаагчид нийгмийн даатгалын талаар мэдээлэл зөвлөгөө өгөх, нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэх, нийгмийн даатгалын ойлголтыг иргэдэд хүргэх зорилгоор ажилтан, албан хаагчид хуваарь гарган хороодын иргэдэд мэдээлэл зөвлөгөө өгөн ажиллаж байна.




Тайлант хугацаанд тус газрын 23 500 дагагчтай цахим хуудсаар дамжуулан иргэд, даатгуулагч, ажил олгогчдод нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд **“Таны хуулийн мэдлэг”** цувралын нийт **10 мэдээлэл** хүргэн ажиллав.



Ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах сургалтын талаар

Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хууль тогтоомжийг мөрдөж нээлттэй, ил тод, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, байгууллагын соёлыг сайжруулахад санал, санаачилга гаргах, Нийгмийн даатгалын аливаа мэдээлэл, судалгааг, давхардуулахгүй байхад анхаарч, бүх шатанд манлайлал үзүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга уриалсан бөгөөд энэ хүрээнд дээд газраас зохион байгуулсан сургалтуудад удирдлага, холбогдох ажилтан албан хаагчид тухай бүр хамрагдаж байна. Тайлант хугацаанд тус газрын ажилтанд албан хаагчид дараах сургалтуудад хамрагдсан.

1. Газрын дарга Б.Энхтөр 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр “Компанийн засаглал” сэдэвт сургалтад хамрагдан сертификатаа гардаж авсан ба сургалтаар компанийн засаглал ба бүтэц, сайн засаглал, удирдлагын арга барил, харилцаа хандлагын талаар ойлголттой болсон. Мөн “Хувь хүний хөгжил, манлайлал” сэдэвт сургалтад хамрагдаж сургалтаар хүний хүний хөгжлийн шинэ сонгодог онол, ёс зүй хандлага, манлайлал, багийн ажиллагаа, цаг ашиглалт ба төлөвлөлтийн талаар ойлголттой болсон.




2. Монгол хэлний тухай хуульд зааснаар албан бичгийг үндэсний болон кирилл бичгээр стандартын дагуу хөтлөн явуулах хөтөлбөрийг үе шаттай

хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд тус газрын ажилтан албан хаагчдыг анхан болон түвшин ахиулах нийт 30 ажилтан, албан хаагчдыг албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор 3 сарын хугацаатай долоо хоногт 2 удаа хоёр цагийн сургалт авч байгаа бөгөөд энэхүү сургалт хөтөлбөрийн дагуу 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр дуусгавар болно.




3. Нийслэлийн Архивын газрын сургалт хариуцсан мэргэжилтэн Б.Наранцацрал нь "Архив, албан хэрэг хөтлөлт, хувийн хэрэг хөтлөлт, шинэчлэн баталсан журам"-ын талаар газрын нийт ажилтан, албан хаагчдад 2 цагийн сургалт зохион байгуулж, сургалтаар хууль тогтоомжид тусгагдсан архивын болон баримт бичгийн стандарт, төрийн албан хэргийн хөтлөлтийн талаар ойлголтыг авч, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.





4. “Хөгжлийн менежмент сургалт, судалгааны төв”-өөс газрын нийт ажилтан албан хаагчдад “Байгууллагын соёл ба үнэт зүйл”, “Хувь хүний хөгжил, бүтээлч хандлага” сэдвийн хүрээнд 2 өдрийн сургалтыг нийт ажилтан, албан хаагчдад орсон бөгөөд сургалтаар ажилтан албан хаагчид байгууллагын соёл ба үнэт зүйлийн хүрээнд хууль эрх зүйн ойлголт, үүсэж болзошгүй ажлын байрны сөрөг хүчин зүйлсийг таньж илрүүлэх урьдчилан сэргийлэх тухай ойлголт, онцгой соёлтой хамт олон бий болгох арга зам зэргийг суралцаж, сургалттай холбоотой тайлан, дүгнэлтийг авсан болно.



5. Тус газрын ажилтан албан, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байх зорилгоор Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар Н.Батчулуун “Авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөл” сэдвийн хүрээнд сургалтыг зохион байгуулан тохиолдож болох авлигын эрсдэл, түүний хор уршиг, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар ойлголтыг авч ажилтан, албан хаагчдын мэдлэг дээшилж, үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан.



6. Мөн төрийн албан хаагчийг ажиллах орчин нөхцөл, тасралтгүй суралцах, мэдлэг ур чадвараа сайжруулахаар цагийн уян хатан нөхцөлөөр 2 жилийн хугацаанд магистрантаар суралцан Рояаль Олон улсын Их сургуульд тус газрын 22 албан хаагчид хамрагдан “Төрийн удирдлага”-ын магистрын зэргээ амжилттай хамгаалж төгссөн.




Тус газрын удирдах түвшний албан хаагчид манлайлал, ур чадварыг сайжруулах зорилгоор Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу мэргэшүүлэх багц сургалтад Удирдлагын академийн ахлах түшмэлийн ангилалд газрын дарга Б.Энхтөр, санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Д.Золзаяа, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад Хамралт, орлогын хэлтсийн дарга Б.Солонго, Нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн тасгийн дарга Ж.Дуламдорж, богино хугацааны мэргэшүүлэх сургалтад Э.Цогт, А.Жавхлан нар тус тус хамрагдаж төгссөн болно.



НАЙМ. ЭМНЭЛЭГ, ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАХ ЧИГЛЭЛЭЭР

➤ Зохион байгуулалтын чиглэлээр

Эрүүл мэндийн магадлалын зөвлөл нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/247 дугаар тушаалаар 10 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн батлагдаж, тайлант оны эхний өдрөөс эхлэн иргэдийг байлцуулахгүйгээр, 100% бичиг баримтанд тулгуурлан нийт 38 удаа хуралдаж, 1542 хүнийг хуралаар хэлэлцүүлсэнээс 363 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоож, 938 хүний хувь, хугацааг сунгаж, биеийн байдал сайжирсан, хяналтын хугацаа дууссан, өндөр насны тэтгэвэр тогтоолгох зэрэг шалтгаанаар 119 хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцалсан байна. Баримт бичгийн шаардлага гүйцэт хангаагүй, эмчийн хяналтын хугацаа болоогүй зэрэг шалтгаанаар 150 иргэний асуудлыг шийдвэрлэхээс түр татгалзаж, буцаасан байна.



Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлүүдийн эмч гишүүд, нарийн бичгийн дарга нарыг оролцуулж, 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 15.00-18.30 цагийн хооронд Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын хурлын танхимд ижил мэргэжилтний үзлэг хийх ажлыг зохион байгуулав. Ижил мэргэжилтний үзлэгт дүүрэг бүрээс ЭММЗ-ийн төрөлжсөн нарийн мэргэжлийн 3 эмч, нарийн бичгийн дарга, магадлагч эмч, нийт 5 гишүүн оролцож, дүүргүүдээс бэлтгэсэн 28 ш картын бичилт, шинжилгээний бүрдэл, хяналтын явц, ЭММЗ-ийн хуралд бэлтгэсэн дүгнэлт, оношны үндэслэлтэй танилцаж, иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтооход баримтлах гарын авлагын шалгуурын дагуу үнэлгээ хийж, дүгнэлтийн дэлгэрэнгүй танилцуулга хийж, харилцан санал солилцов. Нэгтгэсэн саналыг НДЕГ-ын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд хүргүүлэв.






Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн даргын баталсан удирдамж, хувиарийн дагуу Сүхбаатар-Архангай аймгийн Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн эмч гишүүд, нарийн бичгийн дарга нарыг оролцуулж 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн

16:30-18:30 цагийн хооронд Сүхбаатар дүүргийн эмнэлгийн хурлын танхимд ижил мэргэжилтний үзлэг хийх ажлыг зохион байгуулав. Энэхүү ижил мэргэжилтний үзлэгийг ЭММЗ-ийн дарга магадлагч эмч, төрөлжсөн нарийн мэргэжлийн 3 эмч, хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөөлөл, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл, нийт 10 гишүүн оролцож Архангай аймгийн 12 картын бичилт, шинжилгээний бүрдэл, хяналтын явц, ЭММЗ-ийн хуралд бэлтгэсэн дүгнэлт, оношийн үндэслэлтэй танилцаж иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтооход баримтлах гарын авлагын шалгуурын дагуу үнэлгээ хийж, харилцан санал солилцов. Нэгтгэсэн тайланг НДЕГ-ын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлд хүргүүлэв.



Тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу МУ-ын Засгийн газрын 2023 оны 448 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм”-ийн талаар Эрүүл мэндийн төвийн нарийн мэргэжлийн болон өрхийн эмч нарт мэдээлэл өгөх сургалтыг 02 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулж, дүүргийн Эрүүл мэндийн төв, Сэлбэ нэгдсэн эмнэлгийн эмнэлгийн хуудас бичих эрх бүхий эмч, дүн бүртгэлийн мэргэжилтнүүд 45 хүнийг оролцуулав.





ЕС. БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД

Тус газар нь иргэд, даатгуулагч, ажил олгогчид нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлж ажиллахаас гадна ажлын байрны эмх цэгц, иргэд даатгуулагчдад тав тух, таатай орчин бүрдүүлэх, ажлын байрны стандартыг чанд баримтлан, үйлчилгээний чанар, хүртээмж ил тод байдлыг сайжруулж, шуурхай, илүү нээлттэй болгохыг эрхэм зорилго болгон ажиллаж дараах ажлыг хийлээ. Үүнд:

1. Бид Нийгмийн даатгалын байгууллагад “Төрийн байгууллагын төгөлдөршлийн тогтолцооны үнэлгээ, Азийн загвар байгууллага төлөвшүүлэх төсөл”-ийн хүрээнд үйл ажиллагааны чанар, бүтээмжийг дээшлүүлэх, Олон Улсын түвшинд жишиг болохуйц загвар байгууллагыг буй болгох зорилтын хүрээнд “Азийн загвар байгууллага”-ын гэрчилгээг гардан авч төрийн байгууллагад төгөлдөршлийн тогтолцоог нэвтрүүлж, Олон Улсын түвшинд үнэлгдсэн төрийн 4 байгууллагын нэг болсон.





Төслийн хүрээнд газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар 10 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдан Азийн бүтээмжийн төвийн болон Монголын бүтээмжийн төвийн зөвлөхүүдийн удирдалганд дор “Өгөгдөлд суурилсан үйл ажиллагаагаар иргэдийн сэтгэл ханамжийг сайжруулах” төслийг сонгон чиглэл авч, тухай бүр сургалтад хамрагдан амжилт, туршлагаа хуваалцан ажиллаа.

2. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Улсын үзлэг зохион байгуулах тухай” 23 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын удирдамж”-ийн дагуу тус газар нь хамрагдаж, **“Хангалттай”** гэж үнэлүүлсэн. Үзлэгээр өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, баримт бичгийн хадгалалт, цахимжуулалт, бүртгэлийн үе шаттай сайжруулах арга хэмжээг авч ажллаж байгаа бөгөөд 2026 оны газрын төлөвлөгөөнд тусган ажиллахаар төлөвлөж байна.



3. Тус газраас “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, шимтгэлийн өр үүсгэхгүй байх, Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг хангах” сэдвээр хамтарсан уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэс, Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Сүхбаатар дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв болон “Эндээ хөгжил” ТББ хамтран оролцож, 250 гаруй ажил олгогч, жижиг, дунд бизнес эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд Нийгмийн даатгалын



багц хууль, Татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавихад дэмжлэг үзүүлэх, мөн хуулийг хэрэгжүүлээгүйгээс үүсэж болох эсрдлээс урьдчилан сэргийлэх чигэлэлээр мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллаа.



4. Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын 23500 дагагчтай пэйж хуудсаар нийгмийн даатгалын үйлчилгээний төрлөөр 24/7 горимоор чатбот ашиглан, цахимаар мэдээлэл, зөвлөгөө авах боломжийг бүрдүүллээ. Тус үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж эхэлснээр иргэд, даатгуулагч, ажил олгогчид мэдээлэл, зөвлөгөө өгдөг тус газрын утасны дуудлагын тоон ачаалал дунджаар 7000 → 4100 болж буурсан үзүүлэлттэй байна. Мөн чатбот ашиглалтад орсноор ажилтан, албан хаагчдын ажлын ачаалал багасч, ажлын бүтээмж нэмэгдэхийн зэрэгцээ стресс буурах эерэг нөлөө үзүүлж байна.



Нийгмийн даатгалын “Цахим хөтөч”-ийг тус газрын санаачилгаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэмжлэгтэйгээр AR технологи хөгжүүлэгч АРГУН компаниар хийлгэснээр нийгмийн даатгалын байгууллагуудаар үйлчлүүлж буй ажил олгогч, иргэд, даатгуулагчид “Цахим хөтөч”-өөс мэдээлэл авах боломжтой болсон бөгөөд тухайн ажлыг иргэдэд хүргэх зорилгоор Сүхбаатар дүүргийн 11, 15, 16, 17, 18 дугаар хороогоор үйлчлүүлж буй иргэдэд мэдээллийн самбарт байршуулж ажилласан



“Даатгуулагчдыг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил”

Тус газар нь 2024 онд “Стрессгүй хамт олон” уриатайгаар ажилтан, албан хаагчдын ая тухтай, тайван орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор амралтын өргөөг шинээр тохижуулан ашиглалтад оруулсан.

Дээрх урианы хүрээнд 2025 онд байгууллагын ажилтан, албан хаагчдын цагийн менежмент, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, тухтай бөгөөд хамт олны эерэг уур амьсгал бүрдүүлэх зорилгоор тус газрын цайны газрын өрөөг тохижуулж бүрэн дуусгасан.

Энэхүү тохижуулалтын үр дүнд ажилтан, албан хаагчид ажлын завсарлагаагаа зөв төлөвлөн ашиглах, стрессээ тайлах, хамт олонтойгоо үр дүнтэй харилцах боломж бүрдэж байна.



Амралт, чөлөөт цаг

Газрын ажилтан, албан хаагчид нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагаа, үйлчилгээг иргэд, даатгуулагч, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэхээс гадна нэгэн баг болж хамт олноороо Нийгмийн даатгалын ерөнхий газар болон тус дүүргийн Тамгын газраас зохион байгуулж буй үйл ажиллагаанд амжилттай оролцсон. Үүнд:

1. Нийгмийн даатгалын ерөнхий газраас Нийгмийн даатгалын байгууллага үүсэж хөгжсөний 83 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан 5 төрлийн спорт тэмцээнд амжилттай оролцсон.



2. Сүхбаатар дүүргийн Засаг даргын нэрэмжит төрийн албан хаагчдын спортын таван төрөлт тэмцээн зохион байгуулагдсан бөгөөд тус тэмцээнд манай газрын хамт олон амжилттай оролцож Хөгжөөнт буухиа алтан медаль, Волейболын төрөлд эмэгтэй баг алтан медаль, шатрын төрөлд хүрэл медаль хүртэж “ШИЛЖИН ЯВАХ ЦОМЫН ЭЗЭД” боллоо.



3.“Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-т зориулан Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газраас “Хүүхдийн ертөнц” баярын арга хэмжээг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Бэлх захын гадна талбайд зохион байгуулсан арга хэмжээнд тус газрын ажилтан, албан хаагчдаас цуглуулсан гарын бэлгийг хүрэлцэн ирсэн хүүхэд, багачууддаа сугалаа хэлбэрээр бэлэг олгож баярлуулав. Нийт 900 хүүхдэд гарын бэлэг, 100 хүүхдэд сугалаагаар тоглоом бэлэглэлээ.



4.Нийслэлийн хэмжээнд агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын зуухны бүрэн бүтэн байдал, галлагааны аюулгүй байдал, угаарын хийн

мэдрэгч төхөөрөмжийн хэвийн ажиллагаа, агаар бохирдуулагч, хориглосон эд зүйлс шатаж буйд хяналт шалгалт хийж, судалгаа гаргах зорилго бүхий ажилд 2025 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газрын нийт 39 албан хаагч тус дүүргийн 13-р хорооны нутаг дэвсгэрт 5 хэсэгт хуваагдаж гүйцэтгэсэн бөгөөд 1-р хэсэг 137 айл, 2 дугаар хэсэг нь 65 айл, 3 дугаар хэсэг нь 103, 4 дүгээр хэсэг 148, 5-р хэсэг 104 айл нийт 557 айл өрх, нийт 18 аж ахуйн нэгжүүдээр явж судалгаа авлаа. Судалгаанд 11 айл өрх гэртээ байгаагүй, 8 айл өрх хаягтаа амьдардаггүй гэх шалтгаанаар хамрагдаагүй болно.



5. Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай” 4 дүгээр албан даалгаврын дагуу тус газрын нийт 23 ажилтан, албан хаагчид 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 11⁰⁰-12³⁰ цаг хүртэл нийт 90 минутын хугацаанд



дүүргийн Засаг даргын Тамгын газраас хуваарилсан А-3 газар болох Сэлбийн голын эрэг орчмын нийтийн эзэмшлийн зам талбай, гудамж, явган хүний зам



мөн өөрийн байрны 50 метр талбайн ил задгай хог хаягдлыг цэвэрлэн ажилласан болно.



---oOo---